

БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2026/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342716 Цахим хаяг: @audit.gov.mn

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

“Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит” ХХК-ийн захирал: С.Оргил
Утас: 99197346 Цахим хаяг: info@shinjenmagadlakhui-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Аудитын тайлан	10-12
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Материаллаг байдал	10
3.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	11
3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам

Хараат бус аудиторын дүгнэлт



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 282
талай _____ ны № _____ т

ОРХОН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Э.ХИШИГСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 165 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж үүнээс 125 хүүхэд үндсэн сургуульд, насан туршийн боловсролын 40 хүүхэд хөтөлбөрт хамрагдаж гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн Захирал Булган аймгийн боловсролын газрын даргатай 2025 онд байгуулсан гүйцэтгэлгээний төлөвлөгөө нь 4 хөтөлбөр, 85 арга хэмжээний хүрээнд 78.5 хувиар үнэлэгдсэн байна.

6326050408

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	288,372,742.05	339,155,246.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	213,190,579.51	265,173,313.77
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	213,190,579.51	265,173,313.77
3121	Төгрөг	213,190,579.51	265,173,313.77
31211	Төрийн сангийн харилцах	213,190,579.51	265,173,313.77
33	АВЛАГА	759,622.69	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	759,622.69	-
35	БАРАА МАТЕРИАЛ	74,422,539.85	73,981,932.26
351	Түүхий эд материал	1,253,009.40	1,314,976.80
35110	Тусгай зориулалттай материал	1,253,009.40	1,314,976.80
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,423,580.00	1,564,160.00
354	Хангамжийн материал	69,745,950.45	71,102,795.46
35410	Бичиг хэргийн материал	20,000.00	145,000.00
35460	Хүнсний материал	2,418,050.00	1,224,002.00
35470	Бусад хангамжийн материал	67,307,900.45	69,733,793.46
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	370,274,777.54	363,573,134.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	370,274,777.54	363,573,134.44
392	Биет хөрөнгө	347,383,443.66	340,724,300.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	720,030,155.82	769,882,280.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(568,242,642.56)	(585,041,724.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,500,000.00)	(3,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,781,311.40	228,183,315.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(89,261,454.64)	(126,383,586.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,093,906.66	80,191,902.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,766,804.19)	(43,112,846.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,534,393.00	17,534,393.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,735,039.80)	(12,654,052.60)
39217	Ном	11,949,617.97	12,124,617.97
393	Биет бус хөрөнгө	22,891,333.88	22,848,833.96
39301	Програм хангамж	2,750,000.00	3,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,926,666.12)	(2,419,166.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,068,000.00	22,068,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	658,647,519.59	702,728,380.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,690,003.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,690,003.00	-
413	Өглөг	10,690,003.00	-
4136	Бусад өглөг	10,690,003.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	10,690,003.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	647,957,516.59	700,355,730.47
51	Засгийн газрын хувь оролцоо	647,957,516.59	700,355,730.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	290,346,764.02	290,346,764.02
51101	Өмч: - төрийн	290,346,764.02	290,346,764.02
512	Хуримтлагдсан үр дүн	(105,110,945.77)	(52,712,731.89)
51210	Өмнөх үеийн үр дүн	(105,110,945.77)	(105,110,945.77)
51220	Тайлант үеийн үр дүн	-	52,398,213.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	462,721,698.34	462,721,698.34

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	658,647,519.59	700,355,730.47
---	--	----------------	----------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,192,618,750.00	1,296,651,242.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,671,250.00	62,108,092.40
120	Нийтлэг татварын бус орлого	78,671,250.00	62,108,092.40
120009	Бусад орлого	-	387,000.00
120017	Үнэ төлбөргүй авсан -Үндсэн хөрөнгө	71,534,650.00	54,352,125.00
120018	Үнэ төлбөргүй авсан -Бараа материал	7,136,600.00	7,368,967.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,113,947,500.00	1,234,543,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	999,480,800.00	1,106,175,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	999,480,800.00	1,106,175,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,466,700.00	129,838,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,466,700.00	129,838,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1,470,250.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1,470,250.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,213,620,887.77	1,244,253,028.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,213,620,887.77	1,244,253,028.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,195,158,350.63	1,220,053,515.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	684,539,992.42	852,945,673.74
210101	Үндсэн цалин	497,041,806.33	516,751,787.30
210102	Нэмэгдэл	180,646,946.09	279,912,303.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	28,445,000.00
210104	Урамшуулал	6,851,240.00	27,836,582.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,561,082.79	109,797,690.31
210201	Тэтгэврийн даатгал	59,900,587.76	77,433,296.57
210202	Тэтгэмжийн даатгал	6,883,083.59	8,549,732.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,548,259.49	4,289,699.65
210204	Ажилгүйдлийн даатгал	3,193,386.55	3,904,992.34
210205	Эрүүл мэндийн даатгал	12,035,765.40	15,619,969.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,410,262.86	120,785,686.51
210301	Гэрэл, цахилгаан	7,452,992.94	11,871,599.70
210302	Түлш, халаалт	103,957,269.92	108,914,086.81
2104	Хангамж, бараа материалын зардал	5,592,619.42	4,460,106.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	26,400.00
210408	Бараа материал акталсны зардал	5,592,619.42	4,433,706.99
2105	Нормативт зардал	28,591,430.00	36,410,000.00
210502	Хоол, хүнс	28,591,430.00	36,410,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,844,850.00	7,742,800.00
210604	Урсгал засвар	2,844,850.00	7,742,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,438,675.23	9,126,680.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	247,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,438,675.23	8,878,880.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	273,179,437.91	78,784,877.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,043,880.00	12,243,889.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,144,700.00	4,862,220.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	256,990,857.91	61,678,768.10

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,462,537.14	24,199,513.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,274,500.00	23,140,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,274,500.00	23,140,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	188,037.14	1,059,513.49
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	188,037.14	1,059,513.49
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(21,002,137.77)	52,398,213.88
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(21,002,137.77)	52,398,213.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,114,608,300.00	1,234,930,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	660,800.00	442,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	660,800.00	442,000.00
120009	Бусад орлого	660,800.00	442,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,113,947,500.00	1,234,543,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	999,480,800.00	1,106,175,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	999,480,800.00	1,106,175,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,466,700.00	129,838,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114,466,700.00	129,838,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1,470,250.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	1,470,250.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	960,988,685.13	1,185,049,065.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,988,685.13	1,185,049,065.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	940,702,317.99	1,162,545,972.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,299,615.11	854,610,519.58
210101	Үндсэн цалин	460,154,868.68	516,751,787.30
210102	Нэмэгдэл	218,102,406.43	281,577,149.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	28,445,000.00
210104	Урамшуулал	7,042,340.00	27,836,582.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,561,082.79	104,252,821.78
210201	Тэтгэврийн даатгал	58,272,233.28	71,697,975.16
210202	Тэтгэмжийн даатгал	6,831,094.39	8,788,438.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,415,397.20	4,280,646.05
210204	Ажилгүйдлийн даатгал	3,415,397.20	3,845,237.38
210205	Эрүүл мэндийн даатгал	13,626,960.72	15,640,524.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,410,262.86	120,785,686.51
210301	Гэрэл, цахилгаан	6,629,517.80	11,871,599.70
210302	Түлш, халаалт	104,780,745.06	108,914,086.81
2105	Нормативт зардал	28,732,952.00	34,870,952.00
210502	Хоол, хүнс	28,732,952.00	34,870,952.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,868,400.00	7,992,800.00
210604	Урсгал засвар	2,868,400.00	7,992,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,686,475.23	9,989,680.38

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	247,800.00	660,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,438,675.23	9,328,880.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,143,530.00	30,043,512.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,371,990.00	26,439,852.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,771,540.00	3,603,660.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,286,367.14	22,503,093.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,098,330.00	21,443,580.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,098,330.00	21,443,580.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	188,037.14	1,059,513.49
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	188,037.14	1,059,513.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	153,619,614.87	49,881,084.26
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,939,303.00	175,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,939,303.00	175,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,939,303.00	175,000.00
222001	Тоног төхөөрөмж	33,489,303.00	175,000.00
223001	Бусад хөрөнгө	450,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(33,939,303.00)	(175,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	119,680,311.87	49,706,084.26
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		213,190,579.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	213,190,579.51	262,896,663.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(84,084,238.00)	668,984,224.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(84,084,238.00)	668,984,224.36
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(21,002,137.77)	(21,002,137.77)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(105,110,945.77)	647,957,516.59
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(105,110,945.77)	647,957,516.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	52,398,213.88	52,398,213.88
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	290,346,764.02	462,721,698.34	(52,712,731.89)	700,355,730.47

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,207,466,700.00	994,739,950.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,207,466,700.00	960,800,647.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,186,088,200.00	940,702,317.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	844,926,800.00	685,299,615.11
210101	Үндсэн цалин	584,756,900.00	460,154,868.68
210102	Нэмэгдэл	256,521,900.00	218,102,406.43
210104	Урамшуулал	3,648,000.00	7,042,340.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,615,800.00	85,561,082.79
210201	Тэтгэврийн даатгал	71,818,800.00	58,272,233.28
210202	Тэтгэмжийн даатгал	8,449,200.00	6,831,094.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,224,600.00	3,415,397.20
210204	Ажилгүйдлийн даатгал	4,224,600.00	3,415,397.20
210205	Эрүүл мэндийн даатгал	16,898,600.00	1,3626,960.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,799,700.00	111,410,262.86
210301	Гэрэл, цахилгаан	6,663,000.00	6,629,517.80
210302	Түлш, халаалт	104,836,700.00	104,780,745.06
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	0.00
2105	Нормативт зардал	44,902,000.00	28,732,952.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	44,902,000.00	28,732,952.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,868,400.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,868,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,036,800.00	3,686,475.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	247,800.00	247,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,789,000.00	3,438,675.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,807,100.00	23,143,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,718,500.00	19,371,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,088,600.00	3,771,540.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,378,500.00	20,098,330.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,378,500.00	20,098,330.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,378,500.00	20,098,330.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		33,939,303.00
2200	Дотоод эх үүсвэрээр		33,939,303.00
222001	Тоног төхөөрөмж		33,489,303.00
223001	Бусад хөрөнгө		450,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,207,133,700.00	1,113,947,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	999,480,800.00	999,480,800.00

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

131001	Улсын төсвөөс санхүүжих	999,480,800.00	999,480,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	114,466,700.00	114,466,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	114,466,700.00	114,466,700.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	93,186,200.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	93,186,200.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		213,190,579.51
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		265,173,313.77
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шинжлэн Магадлахуй ЭЗШ аудит ХХК”-ийн аудитын баг С.Дарьсүрэн, Б.Хоролбат нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Оргил анхан шатны чанарын хяналтыг, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Булган аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт зардалыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлаас 940,702.3 мянган төгрөгийн 1.5 хувь 14,110.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 10,582.9 мянган төгрөгөөр тогтоосон.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно. Тус байгууллага нь орон нутгийн санхүүжилтээс 1,059.5 мянган төгрөгийг хэмнэн буцаан төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 167 мэдээллийг бүрэн оруулж, 2 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 167 мэдээллийг бүрэн оруулж, 2 мэдээлэл хоцорч мэдээлсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч", Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч" 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ёстой бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

Илрүүлэлт: Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Албан шаардлага/

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөн баталж, дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээх, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх.

3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан шатны ажлыг fas.audit.mn системд хийж гүйцэтгэсэн.

3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах, таслан зогсоох 1 төлбөрийн акт хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

- Тайлант жилд 400.0 мянган төгрөгийг зориулалт бус зардлын зөрчил илэрч төлбөрийн акт
- Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	400.0	1	400.0	100.0
Нийт дүн	1	400.0	1	400.0	100.0

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 3 зөрчил илэрч 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчил нь материаллаг бус зөрчил тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

4.1 Зөвлөмж

4.1.1 Илрүүлэлт: Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байгаа, Бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн долоо хоногт нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -т 'тасралтгүй байх' гэсэн зарчим, 13.1' Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно' гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаг тухай бүрд нь орлого, зарлагын гүйлгээг программд оруулан шивж байх, санхүүгийн программыг бүрэн эзэмшиж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж өгөх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Булган аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн
аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган
төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байгаа, Бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн долоо хоногт нэгтгэн нэг удаа программд шивж оруулсан	1	0					1	0				
Дүн	1	0			0	0	1	0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 167 мэдээллийг бүрэн оруулж, 2 мэдээлэл хоцорч мэдээлсэн	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		
Нийт дүн	2	0			1	0	1	0